



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 1 (334)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *"Цагааннуур" худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай*
- *Конвенцийг соёрхон батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР
УЛААНБААТАР

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2004 оны нэгдүгээр сарын 1

№ 1 (334)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | | |
|----|--|-----------------------|---|
| 1. | "Цагааннуур" худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай | (2003-12-18-ны хууль) | 1 |
| 2. | Конвенцийг соёрхон батлах тухай | (2003-12-18-ны хууль) | 2 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|----|--|-----------|---|
| 3. | Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай | Дугаар 54 | 3 |
| 4. | Элчин сайдын яаманд газар ашиглуулах тухай | Дугаар 55 | 6 |
| 5. | "Цагааннуур" худалдааны чөлөөт бүс байгуулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай | Дугаар 58 | 6 |

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|---|------------|----|
| 6. | Хэлэлцээр батлах тухай | Дугаар 228 | 7 |
| 7. | Дуудлага худалдаагаар худалдах төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн тухай | Дугаар 229 | 7 |
| 8. | Төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулах тухай | Дугаар 230 | 7 |
| 9. | Тогтоолд нэмэлт оруулах тухай | Дугаар 232 | 8 |
| 10. | Төсвийн байгууллагын зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай | Дугаар 233 | 8 |
| 11. | Тогтоолын хавсралт хүчингүй болгох тухай | Дугаар 234 | 11 |
| 12. | Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичгийн тухай | Дугаар 239 | 11 |
| 13. | Төсөв санхүүгийн байдлыг эрүүлжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 240 | 11 |

2003 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

"ЦАГААННУУР" ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь "Цагааннуур" худалдааны чөлөөт бүс /цаашид "Цагааннуур" бүс гэх/-ийн эрх зүйн байдлыг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. "Цагааннуур" худалдааны чөлөөт бүсийн тухай хууль тогтоомж

2.1. "Цагааннуур" бүсийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Чөлөөт бүсийн тухай хууль², энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

¹ Монгол Улсын Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

² Чөлөөт бүсийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.



2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. "Цагааннуур" худалдааны чөлөөт бүсийн нутаг дэвсгэр

3.1. "Цагааннуур" бүс нь Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутаг дэвсгэрт Монгол Улсын Их Хурлаас тогтоосон хилийн зааг бүхий газар нутагтай байна.

4 дүгээр зүйл. Орлогын албан татварын хөнгөлөлт, албан татвараас чөлөөлөх

4.1. "Цагааннуур" бүсэд цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж, авто, төмөр зам, телекоммуникацийн үндсэн сүлжээний салбарт хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн оруулсан хөрөнгийг албан татвар ногдуулах орлогоос хасч тооцно.

4.2. "Цагааннуур" бүсэд агуулахын аж ахуй, ачиж буулгах байгууламж, зочид буудал барьж байгуулахад хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс орлогын албан татвараас 5 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.

4.3. "Цагааннуур" бүсэд бараа, бүтээгдэхүүнийг хадгалах, хамгаалах, сав, баглаа боодлыг сайжруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа 10 болон түүнээс дээш жил ажиллахаар чөлөөт бүсийн захирагчийн ажлын албатай гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс тооцон орлогын албан татвараас

эхний жилд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.

4.4. "Цагааннуур" бүсийн захирагчийн ажлын албанд бүртгүүлэн чөлөөт бүсэд байнга оршин сууж байгаа иргэн, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагыг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас чөлөөлнө.

4.5. "Цагааннуур" бүсийн захирагчийн ажлын албанд бүртгүүлэн бүсэд байнга оршин сууж байгаа иргэн, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын өмчид байгаа үл хөдлөх эд хөрөнгийг Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд худалдан борлуулсан тохиолдолд ногдох орлогын албан татвараас чөлөөлнө.

5 дугаар зүйл. Газрын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт

5.1. "Цагааннуур" бүсэд дараахь чиглэлээр газрын төлбөрийн хөнгөлөлт үзүүлнэ:

5.1.1. худалдаа, нийтийн үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс эхний 3 жилд газрын төлбөрөөс чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө;

5.1.2. энэ хуулийн 4.1, 4.2-т заасан "Цагааннуур" бүсийн үндсэн дэд бүтцийг бүрдүүлэх ажил эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс эхний 5 жилд газрын төлбөрөөс чөлөөлж, дараагийн 3 жилд 30 хувиар хөнгөлнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

КОНВЕНЦИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс 2001 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан Тэрроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон

улсын Конвенцийг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ



2003 оны 12 дугаар сарын 11-ний өдөр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Улаанбаатар хот

Дугаар 54

Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд олон

улсын байгууллага, хандивлагч орнууд, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах ажлыг зохион байгуулахыг Засгийн газар / Н.Энхбаяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Улсын Их Хурлын 2003 оны 54 дүгээр тогтоолын хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК БАЙГУУЛЖ, ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

1. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зорилго

1.1. Үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, оюуны багтаамж өндөртэй технологийг хөгжүүлэх, бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх, дэлхийн зах зээлд Монгол Улсын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулна.

2. Үйлдвэрлэл, технологийн паркийн тодорхойлолт

2.1. Үйлдвэрлэл, технологийн парк гэж макро эдийн засгийн бодлогын хүрээнд үйлдвэрлэл, технологийн хөгжлийн тодорхой зорилтыг хэрэгжүүлэх, бизнесийн тааламжтай орчныг бүрдүүлэх зорилгоор байгуулах, дэд бүтцийн хангамж бүхий тусгайлан заагласан газарт байрлах үйлдвэрлэл, технологийн цогцолборыг хэлнэ.

2.2. Паркт үйлдвэрлэл, технологийн хэд хэдэн нэгж байрлаж болно. Үйлдвэрлэл, технологийн нэгж гэдэгт бие даасан үйлдвэр, үйлдвэрлэл, технологийн инкубатор, эрдэм шинжилгээний байгууллага, түүний салбар, туршилтын лаборатори зэргийг ойлгоно. Үйлдвэрлэл, технологийн парк нь чөлөөт бүсийн хилийн цэсийн дотор байрлаж болно.

3. Үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалт

3.1. Шинэ техник, технологи нэвтрүүлэх замаар бүтээгдэхүүний гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зориулалтаар үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.

3.2. Бүс нутгийн болон гадаад зах зээлд тодорхой байр суурь эзлэх, улс орны эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулах бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зориулалтаар хөгжлийн парк байгуулна.

3.3. Үйлдвэрлэлээс хүрээлэн байгаа орчинд

үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчинд халгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх зориулалтаар үйлдвэрлэл, технологийн парк байгуулж болно.

4. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны хэлбэр

4.1. Үйлдвэрлэл, технологийн парк нь дараах үйл ажиллагааны хэлбэртэй байна:

4.1.1. "холимог"- өөр хоорондоо технологийн хувьд харилцан уялдаагүй хэд хэдэн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг үйлдвэрлэл, технологийн нэгжээс бүрдсэн;

4.1.2. "дагнасан"- нэг чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг, технологийн хувьд харилцан хамаарал бүхий үйлдвэрлэл, технологийн хэд хэдэн нэгжээс бүрдсэн;

4.1.3. "тенант"- иргэдийг ажлын байраар хангах, өршөөл үйлдвэрлэл, үйлчилгээ, жижиг бизнесийг хөгжүүлэх зорилгоор нэг байршилд төвлөрүүлсэн.

5. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зарчим

5.1. Үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулахад дараах зарчмыг баримтална:

5.1.1. макро эдийн засгийн бодлого, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан бүсийн тулгуур төв хотууд, орон нутагт байгалийн баялаг, түүхий эдийн төрөл, нөөцийг харгалзан паркийн зориулалт, хэлбэр, чиглэлийг тогтоох;

5.1.2. дэд бүтцийн хөгжлийн өнөөгийн түвшин, үйлдвэрлэлийн бий болсон бүтэц болон эдийн засгийн салбаруудын хөгжлийн хэтийн төлөвийг харгалзан паркийн байршлыг тогтоох;

5.1.3. паркт эрхлэх үйлдвэрлэл нь оюуны өндөр багтаамж бүхий дэвшилтэт техник, технологи болон мэдээллийн технологийн ололтод



суурилсан байх;

5.1.4. паркт байрших үйлдвэрлэл, технологийн нэгж нь гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадвархи бүхий эдийн засаг, санхүү, технологи, хүний нөөц, маркетингийн чадварлаг менежментээр хангагдсан байх.

6. Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэг

6.1. Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэхэд төрөөс дараахь дэмжлэг үзүүлнэ:

6.1.1. паркт зориулан олгох газрын хил заагийг тогтоож, газар эзэмшигчийг тодорхойлох;

6.1.2. газрын төлбөрийн хэмжээг тогтоож, хөнгөлөлт үзүүлэх;

6.1.3. парк байгуулах зориулалт, хэлбэр, чиглэлийг байршил бүрээр тогтоох;

6.1.4. парк байгуулах үнэлгээ хийлгэх, төлөвлөгөө, төсөл боловсруулах ажлыг зохион байгуулж, эдгээрт шаардагдах санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

6.1.5. паркт үйл ажиллагаа эрхлэх журмыг тогтоох;

6.1.6. паркт өндөр мэргэшлийн гадаад, дотоодын менежер, мэргэжилтэн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

6.1.7. Засгийн газрын олон улсын хамтын ажиллагааны хүрээнд паркт гадаадын хөрөнгө оруулалтыг хэхиүлэн дэмжих;

6.1.8. паркт үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний экспортыг дэмжих. Тухайлбал, татварын бус техникийн хориг саадыг багасгах, чөлөөт худалдааны хоёр талт хэлэлцээр байгуулах, бус нутгийн хүрээнд чөлөөт худалдааны хэлэлцээрт нэгдэн орох арга хэмжээ авах;

6.1.9. паркт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг хөнгөлөлттэй зээл, тусламжийн төсөлд тэргүүн ээлжинд хамруулах;

6.1.10. паркийг дэмжих хөгжлийн сан байгуулах асуудлыг олон улсын байгууллага, хандивлагч орнуудын хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэх;

6.1.11. тенант хэлбэрийн паркийн үйл ажиллагааны чиглэлийг тогтоож, парк байгуулах ажлыг төсвийн болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх.

7. Үйлдвэрлэл, технологийн паркийн дэвсгэр нутагт үйлчлэх эрх зүй, татварын орчин

7.1. Чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт байрлах үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа

явуулж байгаа аж ахуйн нэгжид Чөлөөт бүсийн тухай хуульд заасан эрх зүй, татварын орчин үйлчилнэ.

7.2. Үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжид татварын дор дурдсан хөнгөлөлт үзүүлэх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэнэ:

7.2.1. үйлдвэр барих болон технологийн шинэчлэлт хийх хугацаанд аж ахуйн нэгжийг газрын төлбөрөөс чөлөөлөх, бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлснээс хойш тодорхой хугацаанд газрын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх;

7.2.2. экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжийг тодорхой хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас чөлөөлөх;

7.2.3. экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулан импортлож байгаа түүхий эд, материал сэлбэг, тоног төхөөрөмжийг импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх;

7.2.4. тенант хэлбэрийн парк болон технологийн инкубаторыг үл хөдлөх эд хөрөнгийн болон орлогын албан татвараас чөлөөлөх.

8. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах байршил, зориулалт, хэлбэр, чиглэл

Үйлдвэрлэл, технологийн паркийг дараахь байршил, зориулалт, хэлбэр, чиглэлээр байгуулж, хөгжүүлнэ. Монгол Улсын Засгийн газар энэхүү үндсэн чиглэлд тусгагдсан паркийн чиглэлийг өөрчилж болох бөгөөд паркийн байршлыг өөрчлөх, шинээр парк байгуулах санал гаргаж болно.

1/ Байршил:	Дархан хот
Паркийн нэр:	"Дархан" үйлдвэрлэл, технологийн парк
Зориулалт:	Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл
Хэлбэр:	Дагнасан болон холимог
Чиглэл:	а) хөдөө аж ахуйн түүхий эдийг гүнзгий боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох бүрэн мөчлөг бүхий үйлдвэрлэл;
	б) экспортод зориулсан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл;
	в) электрон техник, компьютер, гэр ахуйн цахилгаан барааг угсрах үйлдвэрлэл;
	г) хөдөө аж ахуйн техник угсрах үйлдвэрлэл.
2/ Байршил:	Зуунмод хот
Паркийн нэр:	"Зуунмод" хөгжлийн парк
Зориулалт:	Хөгжлийн парк
Хэлбэр:	Холимог
Чиглэл:	а) мал, амьтны гаралтай ховор түүхий эдийг боловсруулан



	энзимологи, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийг хөгжүүлэх инкубатор; б) мэдээллийн технологи; в) биотехнологийг хөгжүүлэх инкубатор; г) өндөр зэрэглэлийн савхин жижиг эдлэл, ноолууран нэхмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл.	Хэлбэр: Чиглэл:	Холимог а) хөдөө аж ахуйн түүхий эдийг гүнзгий боловсруулж, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх бүрэн мөчлөг бүхий үйлдвэрлэл; б) экспортод зориулсан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл.
3/ Байршил: Паркийн нэр:	Багахангай дүүрэг Багахангай "Эйрсервис интернэйшнл" парк	7/ Байршил: Паркийн нэр:	Ховд хот "Ховд" үйлдвэрлэл, технологийн парк
Зориулалт: Хэлбэр: Чиглэл:	Үйлчилгээний экспорт Дагнасан олон улсын нислэгийг дамжин өнгөрүүлэх үйлчилгээ /онгоцны буудал, нислэгийн зурвас, агаарын хөлөгт техникийн үйлчилгээ хийх, нислэгийг удирдах цогцолбор/; б) агаарын хөлгийн зорчигчдоод зориулсан хоол хүнсний үйлдвэрлэл.	Зориулалт:	Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл
4/ Байршил: Паркийн нэр:	Чойбалсан хот "Дорнод" үйлдвэрлэл, технологийн парк	Хэлбэр: Чиглэл:	Холимог а) хөдөө аж ахуйн түүхий эдийг гүнзгий боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох бүрэн мөчлөг бүхий үйлдвэрлэл; б) экспортод зориулсан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл.
Зориулалт:	Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл	8/ Байршил: Паркийн нэр:	Налайх дүүрэг "Налайх" бизнесийн инкубатор парк
Хэлбэр: Чиглэл:	Холимог а) эрдэс баялгийг гүнзгий боловсруулах үйлдвэрлэл. Тухайлбал, өндөр цэвэршилтэй нунтаг, металл, давхар исэл үйлдвэрлэх; б) хөдөө аж ахуйн түүхий эдийг гүнзгий боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох бүрэн мөчлөг бүхий үйлдвэрлэл; в) экспортод зориулсан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл.	Зориулалт:	Өрхийн үйлдвэрлэл, жижиг бизнесийг хөгжүүлэх
5/ Байршил: Паркийн нэр: Зориулалт: Хэлбэр: Чиглэл:	Чойр хот "Алтан говь" хөгжлийн парк Хөгжлийн парк Холимог а) эрдэс баялгийг гүнзгий боловсруулах үйлдвэрлэл. Тухайлбал, зэс хайлах, зэсийн цувимал, зэс хоолой, хавтан, зэс утас болон кабель зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх; б) мэдээллийн технологи; в) нүүрс-химийн технологи.	Хэлбэр: Чиглэл:	Тенант а) Өрхийн амьжиргааг дэмжих зорилго бүхий жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ.
6/ Байршил: Паркийн нэр:	Эрдэнэт хот "Эрдэнэт" үйлдвэрлэл, технологийн парк	9/ Байршил: Паркийн нэр:	Сүхбаатар хот "Сэлэнгэ" үйлдвэрлэл, технологийн парк
Зориулалт:	Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл	Зориулалт:	Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл
		Хэлбэр: Чиглэл:	Холимог а) модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл; б) хөдөө аж ахуйн машин механизм угсрах үйлдвэр; в) бордоо, био тэжээлийн үйлдвэрлэл; г) мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл.
		10/ Байршил: Паркийн нэр:	Улиастай хот "Завхан" үйлдвэрлэл, технологийн парк
		Зориулалт:	Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл
		Хэлбэр: Чиглэл:	Холимог а/ бордооны үйлдвэрлэл; б) хөдөө аж ахуйн түүхий эдийг гүнзгий боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох бүрэн мөчлөг бүхий үйлдвэрлэл; в) экспортод зориулсан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл.



9. Үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулж, хөгжүүлэх үе шат

Үйлдвэрлэл, технологийн паркийг дараахь үе шаттайгаар байгуулан хөгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат: 2004-2008 он.

1/ Дархан, Эрдэнэт, Чойр, Сүхбаатар, Ховд хотод үйлдвэрлэл, технологийн парк, Налайх дүүрэгт "Тенант" парк байгуулах ажлыг эхлүүлнэ.

2/ Зуунмод, Чойбалсан, Улиастай хот, Багахангай дүүрэгт парк байгуулах бэлтгэл ажлыг хангаж, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, гадаад орнуудад сурталчлах, хөрөнгө оруулагчдад танилцуулах, хөрөнгийн эх үүсвэрийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн хүрээнд шийдвэрлэх цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хоёрдугаар үе шат: 2008-2012 он.

1/ Дархан, Эрдэнэт, Чойр, Сүхбаатар, Ховд хот, Налайх дүүргийн парк дахь үйлдвэрлэлийн цогцолборыг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулна.

2/ Зуунмод, Чойбалсан, Улиастай хот, Багахангай дүүрэгт үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж эхэлнэ.

10. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж хөгжүүлэх эдийн засаг, нийгмийн үр дүн

10.1. Монгол Улсын ирээдүйн хөгжил, дэвшлийг хангах экспортын чиглэлтэй эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийн бүтэц бий болно.

10.2. Экспортын хэмжээ нэмэгдэж, эдийн засаг өөрийгөө тэтгэн хөгжих боломж бүрдэж, Монгол Улс даяаршиж байгаа дэлхийн зах зээлд тодорхой нэрийн бүтээгдэхүүнээр өөрийн байр суурийг эзэлнэ.

10.3. Үйлдвэрлэлийн хөгжлийг даган дэд бүтэц, үйлчилгээний тогтолцоо эрс сайжирч, ажил эрхлэлт нэмэгдэн, хүн амын амьжиргааны түвшин дээшилнэ.

10.4. Орчин үеийн технологи, менежмент нэвтэрч, үндэсний боловсон хүчний чадавхи дээшилнэ.

10.5. Үндэсний шинжлэх ухаан, техник, технологийн түвшин дээшилж, эрдэм шинжилгээ, судалгааны ажил арилжааны тогтолцоонд шилжиж, боловсрол, шинжлэх ухааны үйлчилгээ, үйлдвэрлэл практикт чиглэгдэх тогтолцоо бий болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

Газрын тухай хуулийн 17.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Элчин сайдын өргөө барихад нь зориулж Монгол Улс дахь Бүгд Найрамдах Турк Улсын Элчин сайдын яаманд 99 жил хүртэл хугацаагаар гэрээний үндсэн дээр газар нэмж ашиглуулахаар тогтсугай.

Элчин сайдын яаманд газар ашиглуулах тухай

2. Туркийн талтай газар ашиглуулахаар гэрээ байгуулж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Цагааннуур" худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/- т даалгасугай:

1/ "Цагааннуур" худалдааны чөлөөт бүсэд зориулан олгох газрын хэмжээ, бүсийн хилийн цэсийг нарийвчлан тодорхойлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

"Цагааннуур" худалдааны чөлөөт бүс байгуулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай

2/ "Цагааннуур" худалдааны чөлөөт бүс байгуулахтай холбогдуулан эхний ээлжинд авах арга хэмжээний төлөвлөгөө гарган дэс дараатай хэрэгжүүлж ажиллах.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Т.Очирхүү/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 10 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 228

Улаанбаатар хот

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2003 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Рига хотноо гарын үсэг зурсан "Соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Латви Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр", 2003 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Вильнюс хотноо гарын үсэг зурсан "Боловсрол, шинжлэх ухаан, соёл, урлагийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Литва Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр", 2003 оны 7 дугаар сарын 1-ний

Хэлэлцээр батлах тухай

өдөр Москва хотноо гарын үсэг зурсан "Боловсролын баримт бичиг, эрдмийн зэрэг, эрдмийн цолыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг тус тус баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд **Ц.НЯМДОРЖ**

Байгаль орчны сайд бөгөөд Боловсрол,соёл,шинжлэх ухааны сайдын үүрэг гүйцэтгэгч **У.БАРСБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр

Дугаар 229

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3, 29 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дулааны Ш цахилгаан станцын хашаанд байрлалтай нэг давхар агуулахын байр, автомашин байрлуулах түр барилгыг нийтийн дуудлага худалдаагаар худалдахыг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд зөвшөөрсүгэй.

2. Дээр дурдсан үл хөдлөх хөрөнгийн худалдагдах үнийн дүнгийн 10 хүртэл хувьд

Дуудлага худалдаагаар худалдах төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн тухай

жерөнгө оруулалтын эрхийн бичгийн баталгаажуулсан ягаан тасалбарыг төлбөрт тооцон авахыг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд **Н.ЭНХБАЯР**

Санхүү, эдийн засгийн сайд **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр

Дугаар 230

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ховд аймагт баригдсан цементийн үйлдвэрийг ашиглалтад орохтой холбогдуулан "Ховд цемент" төрийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулсугай.

2. "Ховд цемент" төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг баталж мөрдүүлэхийг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгасугай.

3. "Ховд цемент" төрийн өмчит үйлдвэрийн газрын жигд ажиллагаа, бүтээгдэхүүний чанарт

Төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулах тухай

хяналт тавьж, мэргэжлийн туслалцаа үзүүлж ажиллахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, тус үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглаж, түлш, эрдэс түүхий эдийн хангамж, ажиллах хүчээр бэхжүүлэхэд дэмжлэг,туслалцаа үзүүлэн холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Ховд аймгийн Засаг дарга Д.Галсандондог нарт тус тус үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Н.ЭНХБАЯР**

Дэд бүтцийн сайд **Б.ЖИГЖИД**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр

Дугаар 232

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

тогтоолын хавсралтын "F.45 Барилга" гэсэн хэсгийн "4530" гэсэн заалтын дараа дор дурдсан хэсгийг нэмсүгэй:

"Жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2001 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 140 дүгээр

Г. 63	6304	Аялал, жуулчлал Тээвэр зохицуулалт, аялал жуулчлалд үйлчлэх үйл ажиллагаа (Жуулчны зориулалттай тусгай сонирхлын аяллын хэрэгсэл)
-------	------	--

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Дэд бүтцийн сайд

Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр

Дугаар 233

Улаанбаатар хот

Төсвийн байгууллагын зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг хэрэгжүүлэх, төрийн албыг боловсронгуй болгох, төсвийн зардлыг хямдруулах ажлын хүрээнд төсвийн байгууллагын зарим ажил, үйлчилгээг бүтээгдэхүүн нийлүүлэх хэлбэрт шилжүүлэн гэрээгээр гүйцэтгүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

багтаан Засгийн газарт танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

1. "Төсвийн байгууллагын зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхэд баримтлах чиглэл"-ийг хавсралт ёсоор баталж уг арга хэмжээг 2003 оны 12 дугаар сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлсүгэй.

4. Төрийн үйлчилгээний зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлж байгаа ажилчдын цалин, бусад зардлыг батлагдсан төсөвт хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зардалд шилжүүлэн тайлан болон нягтлан бодох бүртгэлд тусгаж байхыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвшөөрсүгэй.

2. Энэхүү чиглэлд заасны дагуу ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхдээ одоо ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчдыг хамруулан зохион байгуулсугай.

5. Төсвийн байгууллагын зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхэд төсвийн захирагчтай байгуулах үлгэрчилсэн гэрээний загварыг баталж мөрдүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

3. Төсвийн байгууллагын зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг өөрийн эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах байгууллагынхаа онцлог тохируулан чиглэл өгч ажиллаж ажлын явц, үр дүнг 2004 оны I улиралд

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Санхүү, эдийн засгийн сайд

Ч.УЛААН

Засгийн газрын 2003 оны 233 дугаар тогтоолын хавсралт

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Нэг. Зорилго

1.1. Энэхүү чиглэлийн зорилго нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Засгийн газрын 2002 оны 119 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх, төрийн албаны болон төсвийн шинэчлэлийн хүрээнд төсвийн

байгууллагын зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Төсвийн байгууллагын зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх арга хэмжээнд



шаардлагатай төсвийн бүх шатны байгууллагыг хамруулна.

Гурав. Гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагаа

3.1. Төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрууд нь зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх заавар болон үлгэрчилсэн гэрээг харьяа байгууллагынхаа онцлогт тохируулж боловсруулан төсвийн ерөнхий менежерүүдэд чиглэл өгч ажиллаж, ажлын явцад хяналт тавина.

3.2. Гэрээгээр ажиллах ажилчдыг нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор төрийн үйлчилгээний албан хаагчдыг эхний ээлжинд баг болгон зохион байгуулж төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үйлчилгээ гүйцэтгэж болно.

3.3. Төсвийн байгууллагын зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгоходоо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийг мөрдөнө. Тендерт шалгарсан оролцогч нь одоо ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчдыг баг болгон зохион байгуулах хэлбэрээр ажиллана.

3.4. Тухайн онд гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний чиглэлийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн ажил, үйлчилгээнд зарцуулахаар батлагдсан төсөв, гэрээгээр ажиллах ажилчдын цалингийн сан, шимтгэл, бусад хөнгөлөлт, тэтгэлэг, төрийн өмч, техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, чанар байдлын үнэлгээ, эзэмшин үйл ажиллагаа явуулах ажлын байр болон материаллаг бусад зардал зэргийг бүрэн нэгтгэж гэрээгээр ажиллах ажилчдын ажил, үйлчилгээг худалдан авах зардлыг бүрдүүлнэ.

3.5. Талуудын хүлээх үүргийг гэрээнд тодорхой тусгана. Талууд гэрээг жил бүр хамтран дүгнэж цаашид түүнийг сунгах, цуцлах эсэхийг шийдвэрлэнэ. Төсвийн ерөнхийлөн захирагч

гэрээнд дурдсан төлбөрийг шилжүүлэх үүрэг хүлээнэ.

3.6. Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн төсвийн байгууллагын ажилтны цалинтай уялдуулан гэрээгээр ажиллах ажилчдын ажил, үйлчилгээг худалдан авах зардлыг гэрээгээр тохиролцоно.

3.7. Бүх шатны төсвийн байгууллага нь зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг түргэн шуурхай, чирэгдэлгүй зохион байгуулах ажлыг хариуцна.

3.8. Тухайн төсвийн байгууллагад ажиллаж байгаад үргэлжлүүлэн гэрээгээр ажиллах ажилчдын төрөөс эдлэж байсан хөнгөлөлт (байр, хоол, унааны зардал гэх мэт)-ийг хэвээр үлдээнэ. Харин 2005 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш их, дээд, сургуульд шинээр элсэн орсон нэг хүүхдийнх нь сургалтын зардлыг төлөх асуудлыг төр хариуцахгүй.

3.9. Гэрээгээр ажиллах ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийн улсаас төлж байгаа жөнгөлөлтөд өөрчлөлт оруулахгүй.

Дөрөв. Гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын чиглэл

4.1. Тагнуулын байгууллага, батлан хамгаалах салбарын анги, байгууллагаас бусад байгууллагын цэвэрлэгээ, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулж тэдгээрийн зардлыг бараа, үйлчилгээ худалдан авах зардал хэлбэрээр гэрээний үндсэн дээр өгнө.

4.1.1. Цөөн хүнтэй байгууллагын хувьд үйл ажиллагаа, байршлыг ойр байх нөхцөлийг харгалзан багийг 10-аас доошгүй ажилчидтай байхаар зохион байгуулах боломжийг судлан хэрэгжүүлэх. Тухайлбал: Боловсролын салбарт бүх шатны сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагын цэвэрлэгээ, үйлчилгээ, сантехникийн ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх хэлбэрт шилжүүлнэ. Нийслэл, аймгийн төвд хэд хэдэн сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагыг хамруулсан багуудыг зохион байгуулах. Эрүүл мэндийн салбарт



байршил ойр байх нөхцөлийг харгалзан хэд хэдэн эмнэлэг болон эрүүл мэндийн салбарын бусад байгууллагуудад хамтран цэвэрлэгээ, үйлчилгээ, сантехникийн ажил гүйцэтгэх багуудыг ажиллуулах хэлбэрээр зохион байгуулах. Сумдад төсвийн байгууллагын ажилчид цөөхөн тул сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын байгууллага болон Засаг даргын Тамгын газар зэрэг бүх төсвийн байгууллагыг хамруулан 1 баг байгуулж болно. Төрийн захиргааны бусад байгууллага мөн адил байршил ойр байх нөхцөлийг харгалзан цэвэрлэгээ, үйлчилгээ, сантехникийн ажлыг гүйцэтгэх баг байгуулан ажиллуулах. Энэ тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч тухайн байгууллагуудын ерөнхий менежерүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр уг багтай гэрээ байгуулан ажиллана.

Хамтран баг байгуулан ажиллуулах боломжгүй хэт цөөн ажилчидтай байгууллагууд ажил, үйлчилгээг гэрээт ажилтан буюу хувь хүмүүстэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж болно.

4.1.2. Цэвэрлэгээ, үйлчилгээнд зарцуулах зардлыг байгууллагын нийт талбайн хэмжээ болон одоо уг үйлчилгээг үзүүлж байгаа ажилчдын цалин, бусад зардлыг тусган тооцож хуваарилах тогтолцоонд шилжүүлэх бөгөөд ерөнхий боловсролын сургуулийн хувьд дунд, ахлах ангиудын ангийн талбайг хасч тооцно.

4.2. Эмнэлэг, сургуулиуд, сургуулийн дотуур байр болон бусад төсвийн байгууллагын халаалтын зуух, гал тогооны ажлыг орон тооны ажилчид гүйцэтгэж байгаа байгууллага уг ажлаа түрээсээр гүйцэтгүүлэх хэлбэрт шилжиж цалин, шимтгэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, хөнгөлөлт, жоолны материал, цахилгаан эрчим хүч, түлш халаалт, төрийн өмч, техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, чанар байдлын үнэлгээ, эзэмшин үйл ажиллагаа явуулах ажлын байр болон бусад зардлыг бараа, үйлчилгээ худалдан авах зардалд тусган санхүүжүүлнэ.

4.2.1. Эмнэлэг, сургууль, сургуулийн дотуур байр зэрэг төсвийн газрын халаалтын зуухны галч, механикч, слесарийг гэрээгээр ажиллуулах. Уг үйлчилгээг хэрэглэгчийн

эрх ашигт нийцүүлэн зохион байгуулах ажлыг төсвийн ерөнхий менежер хариуцна.

4.3 Төсвийн байгууллагад ажиллаж байгаа малчин, моторчин, жолооч, слесарь, жижүүр, харуул, манаач, сахиул, худагчин зэрэг бусад төрлийн туслах чанарын болон хугацаа зааж ажиллуулдаг ажилтныг мөн адил гэрээгээр ажиллуулах ажлыг зохион байгуулна.

Тав. Гэрээг цуцлах

5.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь гэрээгээ биелүүлээгүй, хангалтгүй биелүүлсэн болон хууль, тогтоомжид заасан бусад үндэслэлээр гэрээг цуцална.

Зургаа. Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ, албан тушаалын жагсаалт

6.1. Гэрээгээр гүйцэтгэх албан тушаал:

Эмч /байгууллагын/, үйлчлэгч, зөөгч, түгээгч, зарлагач, ердийн хөсөгчин, хувцас өлгөгч, билет шалгагч, ачигч, угаагч, индүүдэгч, хатаагч, амьтан маллагч, хувцас хадгалагч, лифтчин, ариутгах, шатаах зуухны ажилчин, мужаан, хэвлэлийн форм бэлтгэгч /байгууллагын/, сантехник, слесарь, малчин, жолооч /сургууль/, жижүүр, манаач, сахиул, галч, моторчин, бусад.

6.2. Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ:

Санхүү, бүртгэлийн үйлчилгээ, эмнэлгийн тусламж, үйлчилгээ /байгууллагаас/, ном, хэвлэл бэлтгүүлэх, худаг, ус, хоолны газрын үйлчилгээ, цэвэрлэгээ, үйлчилгээ, дулаан, сантехникийн үйлчилгээ, цахилгаан хангамжийн үйлчилгээ, усан, хангамжийн үйлчилгээ, холбооны үйлчилгээ, эрүүл ахуй, ариутгалын үйлчилгээ, барилга засвар, мужааны үйлчилгээ, мод, зүлэг, ногоон байгууламжийн үйлчилгээ, мал маллах, харуул, хамгаалалтын үйлчилгээ, галын аюулгүй байдлын үйлчилгээ, үсчин, гоо сайхны үйлчилгээ, хувцас өлгүүрийн үйлчилгээ, биеийн тамир, урлаг соёлын нийтлэг арга хэмжээ, авто гараагийн болон авто зогсоолын үйлчилгээ, бусад.



<p>2003 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр</p>	<p align="center">МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</p> <p align="center">Дугаар 234</p>	<p align="right">Улаанбаатар хот</p>
<p align="center">Тогтоолын хавсралт хүчингүй болгох тухай</p>		
<p>Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 17.1.4-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>“Журам, дүрэм батлах тухай” Засгийн газрын 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан “Сууц өмчлөгчдийн</p>	<p>холбооны үлгэрчилсэн дүрэм”-ийг хүчингүй болсонд тооцсугай.</p>	<p align="right">Монгол Улсын Ерөнхий сайд</p> <p align="right">Н.ЭНХБАЯР</p> <p align="right">Дэд бүтцийн сайд</p> <p align="right">Б.ЖИГЖИД</p>
<p>2003 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр</p>	<p align="center">МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</p> <p align="center">Дугаар 239</p>	<p align="right">Улаанбаатар хот</p>
<p align="center">Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичгийн тухай</p>		
<p>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх, эдийн засгийн шинэ харилцаанд нийцсэн нийгмийн хамгааллын үйлчилгээг бий болгох талаар тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>“Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг”-ийг сайшааж, уг баримт бичгийг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлыг 2004-2005 онд багтаан зохион байгуулахыг Нийгмийн</p>	<p>хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.</p>	<p align="right">Монгол Улсын Ерөнхий сайд</p> <p align="right">Н.ЭНХБАЯР</p> <p align="right">Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд</p> <p align="right">Ш.БАТБАЯР</p>
<p>2003 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр</p>	<p align="center">МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</p> <p align="center">Дугаар 240</p>	<p align="right">Улаанбаатар хот</p>
<p align="center">Төсөв санхүүгийн байдлыг эрүүлжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай</p>		
<p>Монгол Улсын 2003 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах явцад байгаль, цаг уурын хүндрэлээс шалтгаалж улс, орон нутгийн төсөвт үүсч бий болсон зарим хүндрэлийг арилгаж, төсөв, санхүүгийн байдлыг эрүүлжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1. Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгах нь:</p> <p align="center">а/бүтцийн өөрчлөлт бүрэн хийгдээгүйтэй холбогдон шинээр үүссэн төсвийн өрийг барагдуулах хөрөнгийн эх үүсвэрийг 2003 оны төсөвт төрийн албанаас чөлөөлөгдсөн хүмүүст олгохоор тусгагдсан бүтцийн өөрчлөлтийн сангаас</p>	<p>төсвийн захирагч бүрээр нарийвчлан тооцож олгосугай;</p>	<p align="center">б/тухайн шатны төсвөөс бие дааж барагдуулах бололцоогүй, төлүүлэх тухай шүүхийн шийдвэр гарсан Сэлэнгэ аймгийн төсөвт байгууллагуудын халаалтын зардал 162.0 сая төгрөгийн он дамжсан өрийг 2003 оны төсөвт тусгагдсан өр барагдуулах эх үүсвэрээс, мөн өнгөрсөн өвөл, хаврын цас, зудын хүндрэлээс шалтгаалж хорогдсон 1.2 сая толгой мэлд ногдох мал бүхий иргэний албан татвараар орон нутгийн төсөвт орох байсан 205.1 сая төгрөгийн татварын орлого, гадаадын иргэнд тусгай төлбөртэйгээр агнуулах ангийн хураамжийн орлогын тасалдал</p>



1088.4 сая төрө болон амьсгалын цочмог хамшинж өвчин олон ус орныг хамарсны улмаас Япон Улсаас Моно Улсад жуулчлах жуулчдын тоо эрс бууурч Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яамны иэийн хураамжийн орлогын 2003 оны төлөвлөгөө и хэмжээгээр тасарснаас цаашид хэвийн ажиллах боломжгүй болсон байдлыг харгалзан үзэ, Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яамны үйл ажиллагаанд дутагдаж байгаа хөрөнгийн эх үүсвэрт зориулж 135.1 сая төгрөг, орондгийн төсөвт орох газрын төлбөрийн орлогын эр зйн орчин бүрдээгүйгээс үүссэн зөрүү 4224.4 сая төгрөг, бүгд 1035.0 сая төгрөгийг 2003 оны төсөвт тусгадсан болзошгүй эрсдэлийн сангаас туус тус сакхүүжүүлсүгэй;

в/нэмэгдсэн өртгийн албан тэатварын булан олголтыг 2003 оны төсвийн жилд баагаан тавь төлөгчдөд бүрэн олгож, олон улсын бүүртгэлийг сандартын дагуу нэмэгдсэн өртгийн аалбан тавьын буцаан олголтын данс (сөрөг тсохируулганданс)-нд бүртгэсүгэй;

г/2002-2003 оны өвөлжилтийн бээлтгэлийг янгах ажлын хүрээнд Төв аймгийн Баян-Өнхүл, Өндөрширээт, Дэлгэрхаан, Алтанбулыг умдад олгосон хүн эмнэлгийн түргэн ттусламжинишаины үнэ 19.4 сая төгрөгийг Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын төсөвт ттусагдсан өвлөрсөн арга хэмжээний зардалд баагаан снүүжүүлсүгэй;

д/улсын төсөвт 2002 онд төвлөрүүэ 707.5 сая төгрөгийн орлогыг Баян-Өлгий, Говьүмбэр, Дархан-Уул, Орхон, Төв, Увс, Ховд аймин Засаг дарга нар түүгээрээ дур мэдэн зарцуулснас 2003 онд суутган тооцсон 598.2 сая төгрөгийг орн нутгийн төсвийн хүндрэлтэй байдлыг харгалзан үссэн өрийг нь барагдуулах замаар аймгуудыг тавьсан саналын дагуу буцаан олгосугай;

е/Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хэрэгжилтийг

эрчимжүүлж, зохих бэлтгэлийг хангасны үндсэн дээр 2004 оны төсвийн жилээс эхлэн төсөвт байгууллагуудад амлалтын бүртгэл нэвтрүүлж, төсөвт хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж ажилласугай.

2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгах нь:

а/Засгийн газрын 2002 оны 119 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, төрийн албаны шинэчлэлийн хүрээнд бүтцийн өөрчлөлтийг хийж дуусгах арга хэмжээг шуурхай авч, дүнг энэ оны 12 дугаар сарын 20-ны дотор Засгийн газарт танилцуулсугай;

б/Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2004 оны төсвийн жилээс эхлэн амлалтын бүртгэлийн зарчмаар төсвийн санхүүжилтийг хэрэгжүүлж ажилласугай;

в/олон жил бүртгэл, тайланд тусгагдаж байгаа боловч эзэн нь тодорхойгүй, цаашид барагдах найдваргүй авлагын судалгаа гаргаж, хууль хяналтын байгууллагаар хянуулан цэгцлэх арга хэмжээг энэ онд баагаан авсугай;

г/батлагдсан төсвийг хуульчлан биелүүлж, төсөв хэтрүүлэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулдаг явдлыг таслан зогсоож, үүссэн өр, авлага барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулан, цаашид төсвийн өр, авлага гарах бүх нөхцөлийг хааж, дүнгээ жил бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт Санхүү, эдийн засгийн яаманд хүргүүлж байсугай.

**Монгол Улсын
Ерөнхий сайд**

Н.ЭНХБАЯР

**Санхүү, эдийн
засгийн сайд**

Ч.УЛААН

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хя: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Уланбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 1.5